



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/127

Мөрөн сум

Барилгын ажлыг хүлээж авах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийг дэмжих төвийн их засварын ажлыг хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Д.Мягмарсүрэн (Мэргэжлийн хяналтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)

П.Даваа-Очир (Мэргэжлийн хяналтын газрын Өргөх байгууламжийн хяналтын улсын байцаагч)

Б.Гал-Эрдэнэ (Мэргэжлийн хяналтын газрын Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Ж.Нацагдорж (Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч, хошууч)

Г.Золбоо ("Барилгын хөгжлийн төв"-ийн Барилга байгууламжийн хяналтын хэлтсийн хяналтын инженер)

Б.Аюуш ("Хөвсгөл эрчим хүч" ХХК-ийн ашиглалтын мастер)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Т.Учрал (“Балданс” ХХК-ийн Архитектор)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Д.Ууганбаяр (“Эйч ар ви констракшн” ХХК-ийн Захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Г.Оюунжаргал (Нэгдсэн эмнэлгийн дарга)

Л.Насанжаргал (Нэгдсэн эмнэлгийн Санхүү эдийн засгийн аж ахуйн албаны дарга)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)


2.Барилгын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 6 дугаар сарын 31-ний өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилгын ажлыг хүлээж авахтай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав)-д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга, байгууламжийн ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН